



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН  
ТУШААЛ

2019 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/134

Улаанбаатар хот

Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө,  
хөтөлбөрийн загвар, шаардлага батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөөний загвар, түүнд тавигдах шаардлагыг нэгдүгээр, Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн загвар, түүнд тавигдах шаардлагыг хоёрдугаар, Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн загварыг ашиглах зөвлөмжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, шаардлагыг 2019-2020 оны хичээлийн жилээс мөрдөж эхлэх бэлтгэлийг хангаж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт холбогдох өөрчлөлтийг оруулан мэргэжил (хөтөлбөр)-ийн чиглэл бүрээр 2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор боловсруулж, сургалтад нэвтрүүлэхийг политехник коллежийн захирал нарт даалгасугай.

3. 2019-2020 оны хичээлийн жилээс өмнөх элсэлтийг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, ажиллахыг политехник коллежийн захирал нарт үүрэг болгосугай.

4. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг батлагдсан загвар, шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхэд хяналт тавьж, арга зүйгээр хангах, дүгнэлт гарган баталгаажуулахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Бүсийн арга зүйн төвийн менежерүүдэд үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтийг удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Халиунаа/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын “Техникийн боловсролын загвар батлах тухай” 2015 оны А/262 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



*S. Chinzorig*

С.ЧИНЗОРИГ

## ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАР, ШААРДЛАГА БАТЛАХ ТУШААЛЫН ТАНИЛЦУУЛГА

### 1. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, шаардлагыг шинэчлэн боловсруулж батлах үндэслэл, шаардлага

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1-д “мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх чиглэлээр ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, заавар, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх”, 8.4.10-д “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, дадлагын сургалтын үйл ажиллагааг зохицуулах баримт бичгийг батлах”-аар тус тус заасныг үндэслэн техникийн боловсрол сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загварыг шинэчлэн боловсруулж, түүнд тавигдах шаардлагыг шинээр тогтоохоор Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын төслийг боловсруулаад байна.

#### Үндэслэл:

**Дээд боловсролын тухай хуулийн:** 7.4-т Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцох замаар техникийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтад орсон төгсөгчийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулж болох бөгөөд багц цагийг дүйцүүлэн бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

#### Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн:

9.2.Техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь суралцагчид технологийн процессийг удирдах, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэх бөгөөд ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэж, улмаар хэсэг тус бүрийн агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

9.2.1.Ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид мэргэжил, боловсрол, эзэмшихэд шаардлагатай шинжлэх ухаан, техникийн суурь мэдлэг олгох;

9.2.2.Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологийн чиглэлээр шинэ техник эзэмших, өөрчлөлтөд зохицож хөгжих, тодорхой мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай техникийн суурь мэдлэг, чадвар олгох;

9.2.3.Мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагчид мэргэжлийн үйл ажиллагааны чадвар, дадал эзэмшүүлэх, тухайн мэргэжлээр сонгон мэргэшүүлэх

**MNS 6541:2015 Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага**

Техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэнэ. Хэсэг тус бүрийн агуулга нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Үүнд:

1. Ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид мэргэжил, боловсрол, эзэмшихэд шаардлагатай шинжлэх ухаан, техникийн суурь мэдлэг олгох,
2. Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологийн чиглэлээр шинэ техник эзэмших, өөрчлөлтөд зохицож хөгжих, тодорхой мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай техникийн суурь мэдлэг, чадвар олгох,
3. Мэргэшүүлэх хэсгийн агуулга нь суралцагчид мэргэжлийн үйл ажиллагааны чадвар, дадал эзэмшүүлэх, тухайн мэргэжлээр сонгон мэргэших,
4. Техникийн боловсролын ерөнхий суурь хэсгийн агуулгад дээд боловсролын хөтөлбөрт тусгагдсан заавал судлах багц цагийг тусгахаар тус тус заасан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2019 оны .03 дугаар сарын 28 -ны өдрийн  
ННЗУ дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт



## СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР, ШААРДЛАГА

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Сургалтын төлөвлөгөө нь мэргэжил (хөтөлбөр)-ийн чиглэлээс үл хамааран хичээлийн төрөл, дэс дараалал, онол дадлагын харьцаа, багц цагийн багтаамж, заавал болон сонгон судлах хичээлийг төлөвлөсөн, сургалтын үйл ажиллагаанд мөрдлөг болгох үндсэн баримт бичиг юм.
2. Техникийн боловсрол олгох сургалтын хугацаа 3 жил байх бөгөөд агуулгыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь 90-96 багц цаг байна. Техникийн боловсрол олгох шаталсан сургалтын хугацаа 1.5 жил байх бөгөөд агуулгыг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө нь 54-60 багц цаг байна.
3. Сургалтын төлөвлөгөөг мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж, политехник коллежтой хамтран тухайн хичээлийн жил эхлэхээс 3-аас доошгүй сарын өмнө буюу жил бүрийн 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор баталсан байна.
4. Сургалтын төлөвлөгөөний суралцагчийн эзэмших агуулгын багтаамжийг танхимын сургалтын лекцийн 16 цаг, семинарын 32 цаг, лаборатори, дадлагын 48 цагийг тус тус 1 (нэг) багц цаг гэж тооцно.
5. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөөний 1 (нэг) улирлын үргэлжлэх хугацаа 16 долоо хоногоос багагүй байна.
6. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэх ба сургалтын хугацаанаас хамааран бүрэлдэхүүн хэсгийн харьцааг дараах байдлаар тооцно. Үүнд:
  - 6.1. Ерөнхий суурь хэсэг нь иргэний боловсрол, нийгэм хүмүүнлэг, эдийн засаг, хэл шинжлэл, байгалийн шинжлэх ухааны мэдлэг олгох зэргээр цаашид суралцах үйл явцын тулгуур бүтцийг бий болгоход чиглэсэн техникийн боловсролын суурь судлагдахууныг хамруулна.
  - 6.2. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсгийн агуулгад заавал болон сонгон судлах багц цагийг тусгасан байна.
    - 6.2.1. Техникийн боловсрол олгох болон шаталсан сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсэг нь нийт багц цагийн 35 хувиас ихгүй байна.
    - 6.2.2. Техникийн боловсрол олгох болон шаталсан сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсэгт доорх хүснэгтэд заасан 12 багц цагийг заавал тусгана.

№	Хичээлийн нэр	Багц цаг	Эзэмших чадвар
1	Монголын түүх, соёл, ёс заншил (иргэний боловсрол)	3	Монголын түүхийн үндсэн сурвалж бичгүүдийг /3-аас цөөнгүй/ тоймлон дүгнэж, хөгжилд нөлөөлсөн дотоод, гадаад хүчин зүйлсийн талаар шүүмжит дүгнэлт хийх, түүнийгээ нотлон мэтгэлцэх чадвартай болно.
2	Монгол хэл бичиг, найруулга зүй /яриа бичгийн ур чадвар/	3	Эх хэлээрээ логик дэс дараалалтай үндэслэлтэй, товч тодорхой, үнэн зөв амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадвартай болно. Эрдэм шинжилгээний бичвэр үйлдэх, түүнд дүн шинжилгээ хийх чадвар эзэмшинэ.
3	Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй /хүмүүнлэгийн ухаан/	3	Хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт, өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшинэ.
4	Сэтгэлгээний түүх, соёл /Хүмүүнлэгийн ухаан/	3	Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, философийн үндсэн урсгалууд, тэдгээрийн оюун сэтгэлгээнд үзүүлэх нөлөөг танин мэдэж, цаашид оюунлаг дүгнэлт хийх философи сэтгэлгээний үндсийг эзэмшинэ.
	Нийт	12	

6.2.3. Тухайн мэргэжлийн ерөнхий суурь хэсэгт энэхүү журмын 6.2.2-т зааснаас бусад заавал үзэх хичээлийг сонгохдоо тухайн шинжлэх ухааны салбарт хамаарах багц цагийг нэмж төлөвлөнө.

6.3. Мэргэжлийн суурь хэсэг нь тухайн салбарын болон мэргэжлийн асуудлыг үндэслэлтэйгээр шийдвэрлэх, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын техник технологийн өөрчлөлтөд зохицон хөгжих, бүтээлчээр сэтгэх, мэдлэг, чадвар, хариуцлага, хандлагыг төлөвшүүлэх, ажлын байрны хөдөлмөр хамгаалал, мэргэжлийн ёс зүйтэй холбогдох судлагдахууныг хамруулна.

6.3.1. Техникийн боловсрол олгох (3 жил) сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн суурь хэсэг нь нийт багц цагийн 35 хувиас ихгүй байна.

6.3.2. Техникийн боловсрол олгох (1.5 жил) шаталсан сургалтын төлөвлөгөөний мэргэжлийн суурь хэсэг нь нийт багц цагийн 20 хувиас ихгүй байна.

6.3.3. Энэ суурьт хамаарах хичээлийн агуулгыг өмнө эзэмшсэн мэргэжлийн суурь хэсгийн агуулга болон бакалаврын хөтөлбөрийн агуулгатай нийцүүлсэн хүрээнд тодорхойлно.

6.4. Мэргэшүүлэх хэсэг нь тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах техникийн болон шинжлэх ухааны мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн чиглэлээр гүнзгийрүүлж, судлах судлагдахууныг хамруулна.

6.4.1. Техникийн боловсрол олгох (3 жил) сургалтын төлөвлөгөөний мэргэшүүлэх хэсгийн нийт багц цагийн 30 хувиас ихгүй байна.

6.4.2. Техникийн боловсрол олгох (1.5 жил) шаталсан сургалтын төлөвлөгөөний мэргэшүүлэх хэсгийн нийт багц цагийн 45 хувиас ихгүй байна.

7. Суралцагчдад хөтөлбөрийн хүрээнд агуулгын сонголт хийх боломжтойгоор төлөвлөх бөгөөд нийт багц цагт бүрэлдэхүүн хэсгийн эзлэх хувийг ( $\pm 5$ ) нэмэгдүүлэх болон хорогдуулах зохицуулалт хийж болно.
8. Сонгон судлах хичээл нь тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний багц цагийн хүрээнд өөрт хэрэгцээтэй тодорхой багц цаг бүхий хичээлийг суралцагч өөрөө сонгон судлах боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.
9. Сургалтын төлөвлөгөөнд тухайн мэргэжлийн онцлог, суралцагчийн ачааллыг харгалзан курсын болон төсөлт ажил, төгсөлтийн /диплом/ ажлыг тусгаж болно.
10. Сургалтын төлөвлөгөөний нийт багц цагийн онол, дадлагын харьцааг “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага”-ын 5.2.1-т заасны дагуу тогтооно.
11. Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгийн бүх хичээл нэгдсэн кодтой байна. Сургалтын төлөвлөгөөний хичээл бүрийг 2-3 үсэг, 3 цифрээр кодолно.
  - 11.1. Хичээлийн кодын үсгийг хөтөлбөр хэрэгжүүлэх сургалтын байгууллага, тухайн судлагдахууны ерөнхий нэршил, шатлан суралцах бакалаврын сургалтын хөтөлбөртэй дүйцүүлэн англи үсгээр кодлоно.
  - 11.2. Хичээлийн код нь гурван оронтой тоо зэргээс бүрдэнэ. Гурван оронтой тооны эхний орон уг хичээлийн түвшнийг, дараагийн хоёр орон тухайн хичээлийн дугаар (хичээл хоорондын уялдаа холбоо, эрэмбэ дарааллыг харгалзан тогтооно)-ыг илэрхийлсэн байна. Үүнд:
    - 11.2.1. 001-099 дугаартай бол өмнөх түвшний хичээл (Техникийн боловсролын үндсэн багц цагт тооцохгүй)
    - 11.2.2. 100-199 дугаартай бол техникийн боловсролын ерөнхий суурь хэсгийн хичээл
    - 11.2.3. 200-299 дугаартай бол техникийн боловсролын мэргэжлийн суурь хэсгийн хичээл
    - 11.2.4. 300-399 дугаартай бол мэргэшүүлэх суурь хэсгийн хичээл

БАТЛАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ  
БАЙГУУЛЛАГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
НЭГЖИЙН ДАРГА (ОВОГ, НЭР)

БАТЛАВ. ТУХАЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
ЗАХИРАЛ  
(ОВОГ, НЭР)

... оны ... сарын ... өдөр

..... ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ  
ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

Мэргэжлийн нэр:  
Боловсрол:  
Мэргэшлийн түвшин:

Мэргэжлийн индекс: .....  
Суралцах хугацаа: .....  
Элсэгчид тавигдах шаардлага (боловсрол): .....

№	Хичээлийн нэр	Хичээлийн код	Багц цаг (4+5+6+7)	Хичээлийн бүрэлдэхүүн (багц цагаар)				1 жил		2 жил		3 жил	
				Лекц	Сем/лаб	Дадлага		1	2	3	4	5	6
						СДД	ҮДД						
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
<b>А.Ерөнхий суурь хэсэг- Заавал судлах</b>													
1													
2													
...													
<b>А.Сонгон судлах</b>													
1													
2													
	Дүн												
<b>В. Техникийн /мэргэжлийн/суурь хэсэг- Заавал судлах</b>													
1													
2													
<b>В.Сонгон судлах</b>													
1													
2													
	Дүн												
<b>С. Мэргэшүүлэх хэсэг - Заавал судлах</b>													
1													
2													
	Дүн												
<b>С.Сонгон судлах</b>													
1													
	Дүн												
	НИЙТ БАГЦ ЦАГ												
	НИЙТ ЦАГ												
	Онол дадлагын харьцаа												

Хянасан:

- Төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгжийн асуудал хариуцсан мэргэжилтэн: Гарын үсэг овог нэр огноо
- Сургалтын алба хариуцсан менежер: Гарын үсэг овог нэр огноо

Боловсруулсан: Мэргэжлийн тэнхим, баг

БАТЛАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ  
БАЙГУУЛЛАГЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
НЭГЖИЙН ДАРГА (ОВОГ, НЭР)

БАТЛАВ. ТУХАЙН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
ЗАХИРАЛ  
(ОВОГ, НЭР)

... оны ... сарын ... өдөр

..... ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ  
ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН ШАТАЛСАН  
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

Мэргэжил нэр:

Мэргэжлийн индекс: .....

Боловсрол:

Суралцах хугацаа: .....

Мэргэшлийн түвшин:

Элсэгчид тавигдах шаардлага (боловсрол): .....

№	Хичээлийн нэр	Код	Багц цаг (4+5+6+7)	Багц цаг				1 жил		2 жил
				Хичээлийн бүрэлдэхүүн				1	2	3
				Лекц	Сем/ лаб	Дадлага				
СДД	ҮДД									
0	1	2	3	4	5	6	7	8	9	10
<b>А.Ерөнхий суурь хэсэг- Заавал судлах</b>										
1										
2										
...										
<b>А.Сонгон судлах</b>										
Дүн										
<b>В. Техникийн /Мэргэжлийн/суурь хэсэг- Заавал судлах</b>										
1										
2										
<b>В.Сонгон судлах</b>										
Дүн										
<b>С. Мэргэшүүлэх хэсэг - Заавал судлах</b>										
1										
2										
Дүн										
<b>С.Сонгон судлах</b>										
1										
Дүн										
<b>НИЙТ БАГЦ ЦАГ</b>										
<b>НИЙТ ЦАГ</b>										
<b>Онол дадлагын харьцаа</b>										

Хянасан:


1. Төрийн захиргааны төв байгууллагын холбогдон нэгжийн асуудал хариуцсан мэргэжилтэн: Гарын үсэг, овог нэр, огноо
2. Сургалтын алба хариуцсан менежер: Гарын үсэг, овог нэр, огноо

Боловсруулсан: Мэргэжлийн тэнхим, баг



Мэргэжлийн  
боловсрол  
сургалтын асуудал  
эрхэлсэн төрийн  
захиргааны төв  
байгууллагын лого

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн  
Н.134 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



## ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАР

- Салбарын нэр:** (Тухайн мэргэжил нь нийгэм, эдийн засгийн аль салбарт хамаарахыг тодорхойлон монгол, англи хэлээр бичнэ)
- Мэргэжлийн нэр:** (Техникийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжил (хөтөлбөр)-ийн чиглэл, индекст тусгагдсан мэргэжлийн нэрийг монгол, англи хэлээр бичнэ)
- Мэргэжлийн код, индекс:** (Техникийн боловсрол, сургалтын байгууллагын мэргэжил (хөтөлбөр)-ийн чиглэл, индекст тусгагдсан индексийг бичнэ)
- Мэргэшлийн түвшин:** (Монгол Улсын мэргэшлийн хүрээний хэд дэх түвшинд тус мэргэжил хамаарахыг бичнэ)

БОЛОВСРУУЛСАН ГАЗАР  
БОЛОВСРУУЛЖ, БАТАЛГААЖУУЛСАН ОН

## БАТАЛГААЖИЛТЫН ХЭСЭГ

ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТАД АШИГЛАХЫГ  
ЗӨВШӨӨРӨВ.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ХАРЬЯА  
..... БҮСИЙН АРГА ЗҮЙН ТӨВИЙН МЕНЕЖЕР

(Гарын үсэг)

Овог нэр

..... мэргэжлийн техникийн боловсрол сургалтын хөтөлбөрийг  
боловсруулсан: (Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж хамтран ажилласан гишүүдийн  
мэдээллийг дараах байдлаар оруулна)

Овог, нэр

Албан тушаал  
(цол, зэрэг)

Гарын үсэг

1

2

3

Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрт зөвлөхөөр ажилласан: (Энд  
тухайн мэргэжлээр мэргэшлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн ажилтан, инженер,  
техникийн ажилтан, мэргэшсэн зөвлөх, олон улсын зөвлөх, их, дээд сургуулийн  
мэргэжлийн чиглэлийн доктор, профессорууд ажиллаж болох бөгөөд мэдээллийг дараах  
байдлаар оруулна)

Овог, нэр

Албан тушаал (цол, зэрэг)

Гарын үсэг

Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргасан:  
(Энд БАЗТ-өөс тухайн хөтөлбөрт дүгнэлт гаргасан хөтөлбөр хариуцсан арга зүйчийн  
мэдээллийг мөн дараах байдлаар оруулна)

Овог, нэр

Албан тушаал (цол, зэрэг)

Гарын үсэг

## ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн политехник коллеж нь суралцахуйн үйл явц, үйл ажиллагааг техникийн боловсрол сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт үндэслэн зохион байгуулна.
- 1.2. Техникийн боловсрол, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн нэгдсэн загвар, шаардлагыг тодорхойлж, мэргэжил (хөтөлбөр)-ийн чиглэл бүрээр стандарт, чанарын үнэлгээнд нийцсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдох харилцааг энэхүү загвар, шаардлагаар зохицуулна.
- 1.3. Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөр нь мэргэжил (хөтөлбөр)-ийн чиглэл, суралцах хугацаа зэргээс үл хамааран суралцагчдад олон талт техник технологийн мэдлэг, ур чадварыг олгох, нийгэм, соёлын өөрчлөлт, хэрэгцээнд нийцэн дасан зохицох, хөдөлмөрийн зах зээлд мэргэжлээрээ болон хөрвөн ажиллах цогц чадамжийг эзэмшүүлж, өндөр хариуцлага, зөв хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн баримт бичиг юм.
- 1.4. Сургалтын хөтөлбөрт бүрэлдэхүүн хэсгүүдийн хичээлийн хүрэх үр дүнг тодорхойлсон, уялдаа холбоо бүхий нарийн зохион байгуулалттай, суралцагчийн хөгжлийн ахиц дэвшлийг шатлалаар тодорхойлсон байна.
- 1.5. Техникийн боловсрол, сургалтын суралцагчийн үнэлгээг Мэргэжлийн боловсрол сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран баталсан суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх холбогдох журмаар зохицуулна.
- 1.6. Политехник коллежийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээг Мэргэжлийн боловсрол сургалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн үнэлгээг хийх холбогдох журмаар зохицуулна.

### ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөр нь тогтоосон хугацаанд боловсролын тодорхой шатны сурах, сургах зорилгод хүрэхэд чиглэсэн сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалт, суралцахуйн хэлбэрийг тодорхойлсон цогц баримт бичиг бөгөөд нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагад нийцүүлэн хөтөлбөрийн агуулгыг уян хатнаар өөрчлөн шинэчилж болно.

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

- 3.1. Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөр нь дараах нийтлэг шаардлагыг хангасан, хоорондоо уялдаа холбоо бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:
  - 3.1.1 Хөтөлбөрийн нэр, индекс, түвшин,
  - 3.1.2 Хөтөлбөрийг боловсруулах, хянах, баталгаажуулах хэсэг,
  - 3.1.3 Хөтөлбөрийн танилцуулга,
    - 3.1.3.1. Хөтөлбөрийн тодорхойлолт,
    - 3.1.3.2. Хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлох,
    - 3.1.3.3. Хичээлийн ангиллаар цагийн нэгдсэн төлөвлөлт хийх,
    - 3.1.3.4. Курсын ажил (график тооцооны ажил), төгсөлтийн өмнөх дадлага хийх, улирлын төлөвлөлтийг тооцох,
- 3.2. Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөр (ерөнхий, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх бүрэлдэхүүн хэсэг) –ийн загвар
  - 3.2.1 Тухайн хэсгийн хичээлийн нэр, код,
  - 3.2.2 Тухайн хэсгийн зорилго, зорилтыг тодорхойлох,
  - 3.2.3 Тухайн хэсгийн хичээлийн цагийг төлөвлөх, онол, дадлагыг цагаар тооцох,
  - 3.2.4 Суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар,
  - 3.2.5 Сургалтын хэрэглэгдэхүүн, нэг суралцагчид шаардагдах материал, багаж хэрэгслийн тооцоо,
  - 3.2.6 Суралцах үйл ажиллагаа ба багшийн заах арга зүй,
  - 3.2.7 Суралцагч бие даан судалж, эзэмших мэдлэг, чадварыг тодорхойлох,
  - 3.2.8 Хичээлийн явцын үнэлгээ.
- 3.3. Сургалтын төлөвлөгөө

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- 4.1. Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийг тухайн мэргэжлийн Ажил мэргэжлийн лавлах, Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлагад үндэслэн боловсруулна.
- 4.2. Сургалтын хөтөлбөрийн нэгдсэн дүгнэлтийг энэхүү журмын 4.8-д заасан загварын дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын Бүсийн арга зүйн төв гаргаж, батална.
- 4.3. Сургалтын хөтөлбөрийн төслийг мэргэжлийн тэнхимээр хэлэлцүүлэн, холбогдох хичээл бүрийн төлөвлөлтийг Сургалтын арга зүйч хянаж, Сургалтын менежер батална.
- 4.4. Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрт суралцагчийн бие даан судлах агуулгыг заавал төлөвлөж тусгана.

- 4.5. Сургалтын хөтөлбөрийг энэ журмын нэгдүгээр хавсралтын 3 дахь заалтад тогтоосон хугацаанд загвар, шаардлагад нийцүүлэн батлуулна.
- 4.6. Сургалтын хөтөлбөрийг сайжруулах шаардлагатай гэж үзвэл Техникийн боловсрол олгох шаталсан сургалтын 1.5 жилийн хөтөлбөрийг 3 жил, Техникийн боловсрол олгох 3 жилийн хөтөлбөрийг 6 жилийн хугацаанд сургалтад ашиглаж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дахин шинэчлэн боловсруулж батлуулна.

**Тайлбар,** Сургалт зохион байгуулахад тавигдах шаардлага (Сургалтын орчин, сургалтын тоног төхөөрөмж, суралцагч болон багшид тавигдах шаардлага)-ыг Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлагад тусгасан байх тул сургалтын хөтөлбөрт давхардуулан бичих шаардлагагүй болно.

- 4.7. Бүсийн арга зүйн төв нь сургалтын хөтөлбөрт зөвлөмж өгч болох бөгөөд зөвлөмжийн хүрээнд сургалтын байгууллага шинэчлэн сайжруулах ажлыг 2-4 сарын дотор гүйцэтгэж, батлуулсан байна.
- 4.8. Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргахад доорх үзүүлэлтийг чухалчлан үзэж, дүгнэлтийг дараах загварыг дагуу гаргана. Үүнд:

БАТЛАВ. МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН  
 ..... БҮСИЙН АРГА ЗҮЙН ТӨВИЙН  
 МЕНЕЖЕР (гарын үсэг) ОВОГ.НЭР

.....ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН  
 .....МЭРГЭЖЛИЙН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ,  
 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ДҮГНЭЛТ ГАРГАХ ТУХАЙ

..... оны ... сарын.....өдөр

Мэргэжлийн нэр:  
 Мэргэжлийн индекс:  
 Мэргэшлийн түвшин:  
 Суралцах хугацаа:  
 Судлах багц цаг:

№	Үзүүлэлт	Төлөвлөсөн эсэх болон холбогдох тайлбар		
1	Мэргэжлийн боловсрол сургалтын стандартад үндэслэн боловсруулсан байх	Сургууль боловсруулсан		
		Үндэсний хэмжээнд боловсруулсан		
		Бусад		
2	Сургалтын хөтөлбөрийн бүрэлдэхүүн	Зорилго, зорилт		
3	Судлах цагийн төлөвлөлт /багц цагаар/	Онол, лекц		
		Семинар, лаборатори		
		Дадлага	Сургууль дээрх	
			Үйлдвэр дээрх	
Курсийн ажлын төсөл				
4	Сургалтын хэрэглэгдэхүүн	Багаж, хэрэгсэл		
		Ном, сурах бичиг		
5	Материалын жагсаалт, тооцоо			
6	Үнэлгээний төлөвлөлт			
7	Шаардлага хангасан эсэх			

.....мэргэжлийн хөтөлбөр нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
 ..... оны..... дугаар сарын .....-ны өдрийн .....тоот тушаалаар батлагдсан "Техникийн боловсрол,  
 сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн загвар, шаардлага батлах тухай" тушаалын хоёрдугаар  
 хавсралт дахь хөтөлбөрийн загварын дагуу боловсруулсан, холбогдох шаардлагыг бүрэн  
 хангасан тул сургалтад ашиглах боломжтой гэж дүгнэж байна.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН: АРГА ЗҮЙЧ

(гарын үсэг) ОВОГ. НЭР


**Техникийн боловсрол сургалтын хөтөлбөр**

Сэдвийн нэр	<p><b>Хичээлийн нэр:</b> (Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартад тусгагдсан нэгж хичээлийн нэрийг их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн нэршилтэй ижилсүүлэн дүйцүүлэх нөхцлийг бүрдүүлж, хичээлийн нэрний зөв, оновчтой хувилбарыг сонгон тусгана.) Тухайн хичээл нь сургалтын төлөвлөгөөний аль хэсэгт хамаарахыг энд бичнэ. Тухайлбал, мэргэжлийн болон мэргэшүүлэх суурь хэсэг гэх.мэт <b>Хичээлийн код:</b> (Дээд боловсролын кодлолтой уялдуулан энэхүү журмын нэгдүгээр хавсралтын 11-т заасны дагуу кодолно.)</p>			<p><b>Орох цаг (багц цагаар):</b> <b>Лекц:сем:дад</b> (Энд тухайн зорилтын цагийн төлөвлөлтийг лекц, семинар, дадлагын цагийг харьцуулан бичнэ)</p>	
Зорилт 1: Суралцахуйн үйлээр эцсийн үр дүн буюу суралцагч ямар мэдлэг, ур чадвар эзэмшиж, ямар түвшинд хүрэх үр дүнг тодорхойлон бичнэ. Тухайн зорилгод хүрэх гол алхамууд нь зорилтуудаар илэхийлэгдэх бөгөөд зорилтын тоо нь хичээлийн агуулгын багтаамжаас хамаарна.	<p><b>ЗОРИЛГО:</b> Суралцахуйн үйлээр эцсийн үр дүн буюу суралцагч ямар мэдлэг, ур чадвар эзэмшиж, ямар түвшинд хүрэх үр дүнг тодорхойлон бичнэ. Тухайн зорилгод хүрэх гол алхамууд нь зорилтуудаар илэхийлэгдэх бөгөөд зорилтын тоо нь хичээлийн агуулгын багтаамжаас хамаарна.</p>				
Агуулгын залгамж холбоо (Энэ хичээлийг эзэмшихийн тулд өмнө заавал судалсан байх хичээлийн кодыг бичнэ)	<p><b>Агуулгын залгамж холбоо</b> (Энэ хичээлийг эзэмшихийн тулд өмнө заавал судалсан байх хичээлийн кодыг бичнэ)</p>				
Онол (Мэдлэг олгох)	<p><b>Онол (Мэдлэг олгох)</b></p>				
Зорилт 1: Суралцахуйн үйлээр дамжин зорилгод хүрэх эхний үр дүнг үйлээр илэрхийлэн бичнэ.	<p><b>Зорилт 1:</b> Суралцахуйн үйлээр дамжин зорилгод хүрэх эхний үр дүнг үйлээр илэрхийлэн бичнэ.</p>				
Эзэмшвэл зохих мэдлэг	Суралцах үйл ажиллагаа ба багшийн заах арга зүй	Эзэмшвэл зохих ур чадвар	Суралцах үйл ажиллагаа ба багшийн заах арга зүй		
<p>1. .... 2. .... 3. .... Тухайн хичээлийг судалснаар суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг буюу онолын ойлголтуудыг жагсааж бичнэ.</p>	<p>Багш сургалтын ямар арга барил, хэлбэрийг сонгон, суралцагчтай хэрхэн ажиллах дэвшилтэт технологи зэргийг энд тодорхойлон бичнэ. (Багшийн заах арга барил, туршлагаас хамаарч, хичээлийг удирдан явуулах үйл ажиллагаа нь өөр өөр байж болно)</p>	<p>1. .... 2. .... Тухайн хичээлийг судалснаар суралцагчийн эзэмшвэл зохих ур чадварыг жагсааж бичнэ.</p>	<p>Эзэмшсэн мэдлэгийг ур чадвар болгон хөгжүүлэхэд багш сургалтын ямар арга барил, хэлбэрийг сонгон, суралцагчтай хэрхэн ажиллахыг энд тодорхойлон бичнэ.</p>		
Хэрэглэгдэхүүн	<p>Ном сурах бичиг: (Тухайн хичээлд шаардагдах ном сурах бичгийн номын нэр, хуудасны дугаар, сэдвийг тодорхой заасан байна.) Багаж хэрэгсэл: (Сургалт явуулахад шаардагдах сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, материалын жагсаалтыг энд бичнэ.) Материалын зардлын тооцоо: Материалын нэр Хэмжээ Үнэ Тоо хэмжээ Материалын шинж чанар буюу холбогдох тайлбарыг тусгах</p>				

<p>Сэдвийн нэр</p> <p>1. .... 2. .... 3. ....</p>				<p>Дээрх зорилтыг хангахад нэг суралцагчид ногдох материалын захиалгын тооцооллыг дээрх байдлаар тусгана. (Зарим сэдвийн хувьд материал авах шаардлагагүй тул материалын тооцоо хэсэгт боловсруулалт хийхгүй байж болно.)</p>
<p>1. Энд дээрх зорилтын хүрээнд суралцагчид олговол зохих хандлага төлөвшлийг жагсаан бичнэ. Мөн хандлага төлөвшлийг бий болгоход анхаарах зүйлийг бичиж болно.</p>				
<p>2. Энд дээрх зорилтын хүрээнд байгаль орчны сөрөг нөлөө, хор уршиг, түүнийг бууруулах арга зам, эко хэрэглээний тухай ойлголтыг бичих бөгөөд зарим хичээлийн хувьд энэ агуулга байхгүй буюу тусгах шаардлагагүй байж болно.</p>				
<p>3. Зорилтын хүрээнд тухайн хичээлээр суралцагч бие даан судалж, эзэмших мэдлэг, чадварыг тодорхойлон бичсэн байна.</p>				
<p>4. Зорилт хангагдсан эсэхийг явцын үнэлгээгээр хэрхэн зохион байгуулахыг энд бичнэ.</p>				
<p>Хянасан Сургалтын арга зүйч: Боловсруулсан багш:</p>	<p>гарын үсэг гарын үсэг</p>	<p>(Овог.нэр) (Овог.нэр)</p>		



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын  
2019 оны 03 дугаар сарын 28 -ны өдрийн  
АИЗУ дүгээр тушаалын гуравдугаар хавсралт



## ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ЗАГВАРЫГ АШИГЛАХ ЗӨВЛӨМЖ

Техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу “Хөтөлбөрийн танилцуулга” хэсгийг дараах байдлаар боловсруулж, хөтөлбөрийн бүрэлдэхүүн болгосон байна.

Тухайн мэргэжлийн хөтөлбөрийн тодорхойлолт, хөтөлбөрийн зорилго, зорилт, хичээлийн ангиллын цагийн нэгдсэн төлөвлөлт, курсын ажил, сургууль дээрх, үйлдвэрлэл дээрх болон төгсөлтийн өмнөх дадлага хийх улирлын төлөвлөлтийг хийнэ.

Тухайн мэргэжлийн хөтөлбөрийн тодорхойлолт нь ажил мэргэжлийн тодорхойлолттой уялдсан байх ба хөтөлбөрийн зорилго, зорилт нь хөтөлбөрийн тодорхойлолтыг хангана.

Хичээлийн ангиллын цагийн нэгдсэн төлөвлөлт нь сургалтын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн багц цаг, судлах цагтай нийцтэй байна.

Хөтөлбөрийн танилцуулгыг “График дизайнч” мэргэжлээр жишээ авч үзвэл:

### ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

#### 1. Хөтөлбөрийн тодорхойлолт

Үйлдвэрлэлийн дэвшилтэт технологийн хөгжлийг мэдэрч, хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангасан, гоо сайхны таашаалд нийцэхүйц, зохион бүтээлт, технологийн шаардлага хангахуйц бүтээгдэхүүн үйлдвэрлэгч мэргэжилтэй ажилтан бэлтгэж, дизайн урлагийг нийгмийн үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгыг агуулна. Техникийн боловсролын дипломын зэрэгтэй график дизайнер нь мэргэшсэн чиглэлээрээ бие даан болон үйлдвэрлэл, соёл үйлчилгээний байгууллага, мультимедиа студи, телевизийн студид вэб дизайнер, зохион бүтээх дизайнер,

#### 2. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн шаардлагыг хангахуйц, мэргэшлийн түвшний тогтолцоотой уялдсан уян хатан сургалтыг “График дизайнч” мэргэжлээр зохион байгуулах техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн агуулгыг тогтоож, хэрэгжүүлэхэд оршино.

- Хувь хүн болон байгууллагын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхэд нь график дизайны шийдлүүдийг гүйцэтгэх,
- Байгууллагын брэнд бүрдүүлэлт хийх,
- Бүх төрлийн хэвлэмэл материалын дизайн гаргаж, хэвлэх,
- Хувь хүн болон байгууллагад шаардлагатай зураг авалт, бичлэг хийх,
- Зураг, дуу, видеог чанарын өндөр түвшинд монтаж буюу эвлүүлэг хийх,

- Дуу, видео бичлэгийн студид эвлүүлэгчээр, график дизайнчийн ажил үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, чадвар олгох,
- Амьдралын бүхий л зүйлд дизайны шийдэл байдгийг ойлгуулах,
- Ажил, амьдрал болон олон нийтэд компьютер график дизайны хувь нэмрийг оруулах

3. Төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг тус бүрт тусгасан хичээлийн цагийн нэгдсэн төлөвлөлт /3 жил/

Д/д	Төлөвлөгөөний бүрэлдэхүүн	Багц цаг	Нийт цаг
1	Ерөнхий суурь хэсэг	30	768
	Сонгон судлах	3	80
2	Техникийн/Мэргэжлийн суурь хэсэг	27	902
	Сонгон судлах	6	176
3	Мэргэшүүлэх хэсэг	18	512
	Төгсөлтийн өмнөх дадлага	8	384
	Сонгон судлах хэсэг	4	96
	Нийт	96	2918

4. Курсын ажил, төгсөлтийн өмнөх дадлага хийх улирлын төлөвлөлт

4.1. Курсын ажлыг 3-р курсын эхний улиралд гүйцэтгэнэ.

4.2. Төгсөлтийн өмнөх дадлагыг 3-р курсын 2-р улиралд хийнэ.

4.3. Курсын болон төгсөлтийн өмнөх дадлагыг дараах удирдамжийн дагуу хийнэ.

4.3.1. Курсын ажил гүйцэтгэх удирдамж

- Хөтөлбөрийн агуулгын хүрээнд сэдэв сонгох,
- Курсын ажлын зорилго, зорилтыг тодорхойлох,
- Курсын ажлын бүтээл гаргах журам,
- Курсын ажлын төлөвлөгөө,
- Загвар гаргах, үйл явцыг төлөвлөх,
- Үнэлгээ болон үнэлэх арга,
- Эргэх холбоо,
- Холбогдох маягт,
- Дэлгэрэнгүй мэдээлэл: Овог нэр, агуулга, үнэлгээ, хугацаа, хариуцсан эзэн, санал хүсэлт г.м

4.3.2. Төгсөлтийн өмнөх дадлага хийх удирдамж

- Үйлдвэрлэлийн дадлагын тодорхойлолт болон зорилго,
- Үйлдвэрлэлийн дадлага хийлгэх дүрэм болон үйл явц,
- Түншлэгч байгууллагын дадлага хийлгэх агуулга,

- Үнэлгээ болон үнэлэх арга,
- Дадлагажигч болон түншлэгч байгууллагын холбоо харилцаа,
- Дадлагажигчийн сэтгэл ханамжийг харгалзан түншлэгч байгууллагыг сонгох,
- Эргэх холбоо,
- Холбогдох маягт,
- Дэлгэрэнгүй мэдээлэл: Овог нэр, агуулга, үнэлгээ, хугацаа, хариуцсан эзэн, санал хүсэлт г.м

--- о О о ---